



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхайрхан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/171/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Улиастай сум  
2024 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: [Bat-Undraa@audit.gov.mn](mailto:Bat-Undraa@audit.gov.mn)

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: [Boldbaatarkh@audit.gov.mn](mailto:Boldbaatarkh@audit.gov.mn)

Ахлах аудитор: Ц.Оюунсүвд

Утас: 99076038

Цахим хаяг: [oyunsuvdts@audit.gov.mn](mailto:oyunsuvdts@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. Аудитын илрүүлэлт .....	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

---

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улаанбаатар, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12  
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2024.02.06 № 31

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**БАЯНХАЙРХАН СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА Х.ОЮУНЧИМЭГ-Т**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхайрхан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхайрхан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Баянхайрхан сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд урсгал засварын зардлаас 19,000.0 мянган төгрөгөөр ундны усны худаг засварлаж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас шонхор шувууны бүс нутаг тогтоох, үүр барих ажилд 25,000.0 мянган төгрөг, шонхор шувууг хамгаалахаар камер, дрон худалдан авахад 22,900.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна. Улсын онцгой комиссоос 141,800.0 мянган төгрөгийн автомашин олгож, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 105,825.0 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй нэмэгдсэн байна. Өвөлжилт хүндэрч өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхэд 14,582.2 мянган төгрөг зарцуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Баянхайрхан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс аймгийн 100 жилийн ойн арга хэмжээний хоол хүнсний материалд 3,456.5 мянган төгрөг, аймаг, сумын аварга малчид, оны тэргүүний шагналд 3,720.0 мянган төгрөг, шатахууны зардлаас Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын нутгийн зөвлөлийн золголт, аймгийн ИТХ-ын хуралдаанд оролцох зэрэгт 2,837.9 мянган төгрөгийн шатахууныг зориулалт бус үрэлгэн зарцуулж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн байна.

0120-0020

Audit(D)Зөвлөмж/2024

### **Бусад асуудлын хэсэг**

Баянхайрхан сумын Засаг даргын Тамгын газар Шилэн дансны цахим мэдээллийн системд байгууллагын урсгал санхүүжилт, хөрөнгө зарцуулах шийдвэрүүдийг тухай бүр мэдээлсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>12,701,489.90</u></b>	<b><u>68,792,229.36</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	12,701,489.90	68,792,229.36
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	1,919,500.00	1,919,500.00
35110	Тусгай зориулалттай материал	1,919,500.00	1,919,500.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	10,781,989.90	57,172,729.36
35410	Бичиг хэргийн материал	1,688,810.00	2,543,630.00
35420	Аж ахуйн материал	477,100.00	532,100.00
35440	Түлш, шатах тослох материал	3,511,079.90	10,979,199.36
35470	Бусад хангамжийн материал	5,105,000.00	43,117,800.00
35600	Мал амьтад	-	9,700,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>578,696,950.65</u></b>	<b><u>805,122,738.60</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	578,696,950.65	805,122,738.60
391	Газар	5,908,000.00	8,620,000.00
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	571,252,267.49	795,528,555.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	338,161,990.00	338,161,990.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(47,756,666.10)	(69,346,072.62)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	138,531,234.00	325,531,234.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(93,720,035.09)	(107,168,734.05)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	75,455,242.00	91,530,242.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(35,774,245.42)	(46,458,708.62)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,438,910.00	13,678,210.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,268,025.84)	(3,958,548.78)
39209	Зам, гүүрний байгууламж	9,179,103.00	34,179,103.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(4,360,073.64)	(5,902,362.10)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	3,660,000.00	3,660,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	348,414,062.00	404,814,462.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(166,978,127.42)	(183,192,259.39)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	1,536,683.16	974,183.16
39301	Программ хангамж	3,077,000.00	3,077,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,540,316.84)	(2,102,816.84)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>591,398,440.55</u></b>	<b><u>873,914,967.96</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>591,398,440.55</u></b>	<b><u>873,914,967.96</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	591,398,440.55	873,914,967.96
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	279,825,085.40	279,825,085.40
51101	Өмч: - төрийн	279,825,085.40	279,825,085.40
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	139,950,789.90	422,467,317.31
51210	Өмнөх үеийн үр дүн	(19,344,620.81)	139,950,789.90
51220	Тайлант үеийн үр дүн	159,295,410.71	282,516,527.41
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	171,622,565.25	171,622,565.25
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>591,398,440.55</u></b>	<b><u>873,914,967.96</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>625,219,584.03</b>	<b>908,957,237.36</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>199,334,513.07</b>	<b>290,572,500.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	199,334,513.07	290,572,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	199,334,513.07	290,572,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	199,334,513.07	290,572,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>425,885,070.96</b>	<b>618,384,737.36</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	172,724.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	172,724.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	93,599,346.96	87,092,583.36
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	90,800,000.00	86,972,583.36
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,799,346.96	120,000.00
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	332,113,000.00	531,292,154.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	322,113,000.00	531,292,154.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	10,000,000.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>459,326,697.18</b>	<b>626,171,809.95</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>459,326,697.18</b>	<b>626,171,809.95</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	376,103,193.22	612,402,880.27
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	180,771,406.23	320,411,417.31
210101	Үндсэн цалин	153,373,938.76	222,512,087.45
210102	Нэмэгдэл	22,503,969.74	75,255,588.86
210104	Урамшуулал	4,893,497.73	22,643,741.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	23,449,034.37	40,590,632.46
210201	Тэтгэврийн даатгал	16,099,568.75	27,758,661.66
210202	Тэтгэмжийн даатгал	1,894,079.36	3,265,724.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,433,632.84	2,559,779.97
210204	Ажилгүйдлийн даатгал	384,819.60	630,987.38
210205	Эрүүл мэндийн даатгал	3,636,933.82	6,375,478.56
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	17,211,268.40	15,143,583.55
210301	Гэрэл, цахилгаан	1,376,900.40	2,118,693.55
210302	Түлш, халаалт	15,834,368.00	13,024,890.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	25,005,576.10	29,823,887.90
210401	Бичиг хэрэг	2,563,810.00	2,196,380.00
210402	Тээвэр, шатахуун	19,105,587.10	24,759,907.90
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,368,780.00	2,820,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	53,000.00	47,600.00
210408	Бараа материал акталсны зардал	914,399.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,713,700.00	5,404,300.00
210604	Урсгал засвар	4,713,700.00	5,404,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	6,750,000.00	9,265,000.00
210702	Дотоод албан томилолт	6,750,000.00	9,265,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	13,885,258.00	1,350,615.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,999,580.00	300,000.00

210803	Даатгалын үйлчилгээ	469,000.00	469,075.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	154,874.00	236,364.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	73,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	119,000.00	203,400.00
210807	Газрын төлбөр	76,804.00	67,976.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>104,316,950.12</b>	<b>190,413,444.05</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,109,900.00	89,662,632.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00	5,198,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	62,107,050.12	95,552,812.05
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>83,223,503.96</b>	<b>13,768,929.68</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>83,223,503.96</b>	<b>13,768,929.68</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	83,223,503.96	13,768,929.68
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>165,892,886.85</u></b>	<b><u>282,785,427.41</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>6,597,476.14</b>	<b>268,900.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	6,597,476.14	268,900.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН</b>	<b>(6,597,476.14)</b>	<b>(268,900.00)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>159,295,410.71</u></b>	<b><u>282,516,527.41</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (</b>	<b><u>426,060,071.0</u></b>	<b><u>618,384,737.4</u></b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>426,060,071.0</b>	<b>618,384,737.4</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	172,724.0	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	172,724.0	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>93,599,347.0</b>	<b>87,092,583.4</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	90,800,000.0	86,972,583.4
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,799,347.0	120,000.0
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>332,113,000.0</b>	<b>531,292,154.0</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	322,113,000.0	531,292,154.0
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	10,000,000.0	-
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>175,000.0</b>	<b>-</b>
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	175,000.0	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>399,360,071.0</u></b>	<b><u>576,484,737.4</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>399,360,071.0</b>	<b>576,484,737.4</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>316,136,567.0</b>	<b>562,715,807.7</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>180,245,464.3</b>	<b>320,463,667.3</b>
210101	Үндсэн цалин	152,847,997.4	222,564,337.5
210102	Нэмэгдэл	22,503,969.9	75,255,588.9
210104	Урамшуулал	4,893,497.1	22,643,741.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>23,974,976.3</b>	<b>40,538,382.5</b>
210201	Тэтгэврийн даатгал	16,564,147.9	27,711,911.7
210202	Тэтгэмжийн даатгал	1,909,453.6	3,260,224.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,448,616.8	2,559,780.0
210204	Ажилгүйдлийн даатгал	368,550.7	630,987.4
210205	Эрүүл мэндийн даатгал	3,684,207.2	6,375,478.6

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	20,811,268.4	15,343,583.6
210301	Гэрэл, цахилгаан	1,376,900.4	2,118,693.6
210302	Түлш, халаалт	19,434,368.0	13,224,890.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	21,065,080.0	28,880,308.4
210401	Бичиг хэрэг	3,177,200.0	2,922,200.0
210402	Тээвэр, шатахуун	14,821,900.0	23,138,108.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,065,980.0	2,820,000.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,844,700.0	8,314,900.0
210604	Урсгал засвар	4,844,700.0	8,314,900.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	6,750,000.0	9,265,000.0
210702	Дотоод албан томилолт	6,750,000.0	9,265,000.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	17,043,078.0	2,250,615.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,157,400.0	1,200,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	469,000.0	469,075.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	154,874.0	236,364.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.0	73,800.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	119,000.0	203,400.0
210807	Газрын төлбөр	76,804.0	67,976.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	41,402,000.0	137,659,351.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,100,000.0	132,361,351.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	302,000.0	5,298,000.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>83,223,504.0</b>	<b>13,768,929.7</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	83,223,504.0	13,768,929.7
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	83,223,504.0	13,768,929.7
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>26,700,000.0</b>	<b>41,900,000.0</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН</b>	<b>26,700,000.0</b>	<b>41,900,000.0</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>26,700,000.0</b>	<b>41,900,000.0</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	26,700,000.0	41,900,000.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	26,700,000.0	41,900,000.0
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(26,700,000.0)</b>	<b>(41,900,000.0)</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгсгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	279,825,085.4	171,622,565.3	-19,344,620.8	432,103,029.8
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	279,825,085.4	171,622,565.3	-19,344,620.8	432,103,029.8
C07	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	159,295,410.7	159,295,410.7
C08	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	279,825,085.4	171,622,565.3	139,950,789.9	591,398,440.6
D01	2023 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	279,825,085.4	171,622,565.3	139,950,789.9	591,398,440.6
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	279,825,085.4	171,622,565.3	139,950,789.9	591,398,440.6
D08	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	282,516,527.4	282,516,527.4
D09	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	279,825,085.4	171,622,565.3	422,467,317.3	873,914,968.0

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ЭЗА	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	565,748,600.0	517,523,224.3
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	565,748,600.0	517,523,224.3
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	565,748,600.0	517,523,224.3
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	339,121,000.0	320,463,667.3
210101	Үндсэн цалин	242,825,300.0	222,564,337.5
210102	Нэмэгдэл	96,295,700.0	75,255,588.9
210104	Урамшуулал	-	22,643,741.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	42,390,200.0	40,538,382.5
210201	Тэтгэврийн даатгал	28,825,300.0	27,711,911.7
210202	Тэтгэмжийн даатгал	3,391,200.0	3,260,224.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,713,600.0	2,559,780.0
210204	Ажилгүйдлийн даатгал	677,600.0	630,987.4
210205	Эрүүл мэндийн даатгал	6,782,500.0	6,375,478.6
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	15,897,100.0	15,343,583.6
210301	Гэрэл, цахилгаан	2,672,200.0	2,118,693.6
210302	Түлш, халаалт	13,224,900.0	13,224,890.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	23,123,900.0	22,473,500.0
210401	Бичиг хэрэг	2,922,200.0	2,922,200.0
210402	Тээвэр, шатахуун	16,751,300.0	16,751,300.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,450,400.0	2,800,000.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	8,314,900.0	8,314,900.0
210604	Урсгал засвар	8,314,900.0	8,314,900.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	14,910,100.0	8,525,000.0
210702	Дотоод албан томилолт	14,910,100.0	8,525,000.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,388,000.0	2,250,615.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,200,000.0	1,200,000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	560,000.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	469,100.0	469,075.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	727,700.0	236,364.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	73,800.0	73,800.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203,400.0	203,400.0
210807	Газрын төлбөр	138,300.0	67,976.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15,700.0	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	118,603,400.0	99,613,576.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	113,300,000.0	94,315,576.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,303,400.0	5,298,000.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	565,748,600.0	517,523,224.3
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	565,748,600.0	517,523,224.3
122005	Орон нутгийн төсвөөс	565,748,600.0	517,523,224.3

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>87,092,583.4</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>87,092,583.4</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>87,092,583.4</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>0.00</b>	<b>6,406,808.4</b>

210402	Тээвэр, шатахуун	-	6,386,808.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	20,000.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	0.00	19,000,000.0
210604	Урсгал засвар	-	19,000,000.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	0.00	740,000.0
210702	Дотоод албан томилолт	-	740,000.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	0.00	60,945,775.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	60,945,775.0
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	87,092,583.4
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.00	87,092,583.4
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	86,972,583.4
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	120,000.0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

##### Баянхайрхан сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны чиглэл:

- Иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэх

**Баянхайрхан сумын Засаг даргын Тамгын газрын зорилго:** Төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг оновчтой зохион байгуулж мэргэшсэн төрийн албан хаагчаар төрийн албыг бүрдүүлэн иргэдэд төрийн үйлчилгээг ил тод шуурхай тэгш хүртээмжтэй хүргэх сум орон нутгаа хөгжүүлэх гэсэн зорилго зорилт чиг үүргийн хүрээнд ажилладаг байна. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 88 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Баянхайрхан сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
2. Төрийн албаны тухай хууль
3. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
4. Төсвийн тухай хууль
5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
6. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
7. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
8. Хөдөлмөрийн тухай хууль
9. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Сумын ЗДТГ-ын дэргэд дотоод аудитын чиг үүрэг бүхий аудитор, дотоод хяналтын нэгж байхгүй байна. Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд Тамгын газрын дарга, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхайрхан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхайрхан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 280,433.2 мянган төгрөгөөр буюу 47.4 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	12,701.5	43,792.2	31,090.7
Үндсэн хөрөнгө	578,696.9	828,039.4	249,342.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>591,398.4</b>	<b>871,831.6</b>	<b>280,433.2</b>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	591,398.4	871,831.6	280,433.2
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>591,398.4</b>	<b>871,831.6</b>	<b>280,433.2</b>

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

#### Тайланд онд:

Бараа материалын эхний үлдэгдэл 12,701.5 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 73,109.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 10,225.0 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 52,243.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 43,792.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 31,090.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 66,900.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтаар 247,625.0 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр, мөн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ч цаашид ашиглагдах боломжтой хөрөнгүүдэд үнэ тогтоож 30,010.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, 12,873.9 мянган төгрөгийн хөрөнгө шийдвэрийн

дагуу акталж, жилийн эцэст 819,419.4 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 97,636.1 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 280,433.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 404,504.4 мянган төгрөг, нийт зарлагыг 404,504.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Энэ нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, тээвэр шатахуун, дотоод албан томилолтын зардлыг хасаж, Засаг даргын нөөц хөрөнгийг тодотголоор нэмсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 565,748.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 517,523.2 мянган төгрөг буюу 92.5 хувьтай байна. Энэ нь цалин, гэрэл цахилгаан, шуудан холбоо, дотоод албан томилолтын зардлыг 3,704.0 мянган төгрөгөөр, Засаг даргын нөөц хөрөнгөөс 3,176.4 мянган төгрөг, байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас 15,808.0 мянган төгрөгийг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>					
Хөтөлбөр арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>					
<b>70106</b>	<b>Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага</b>				
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	355,459.6	351,755.6	3,704.0	98.9%
80106	Баг, хорооны үйл ажиллагааны зарлал	70,789.0	70,252.0	537.0	99.2%
80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	1,200.0	1,200.0	-	100%
81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	36,000.0	32,823.6	3,176.4	91.2%
81701	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	77,300.0	61,492.0	15,808.0	79.5%
<b>НИЙТ</b>		<b>565,748.6</b>	<b>517,523.2</b>	<b>48,225.4</b>	<b>92.5%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 87,092.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 87,092.6 мянган төгрөгийг тээвэр шатахуун, дотоод албан томилолт, бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

*/мянган төгрөг/*

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Шууд гэрээ байгуулах	Худаг засварлах	19,000,000	19,000,000
2	Шууд гэрээ байгуулах	Дрон худалдаж авах	9,600,000	9,600,000
3	Шууд гэрээ байгуулах	Шонхор шувууны хиймэл үүр барих	15,000,000	15,000,000
4	Шууд гэрээ байгуулах	Шонхор шувууны бүс тогтоох	10,000,000	10,000,000
ДҮН			<b>53,600,000</b>	<b>53,600,000</b>

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхайрхан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторовын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Баянхайрхан сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 03/11 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгө 591,398.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,870.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн

материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6.653.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэн, 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт хөрөнгө 873,914.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 13,108.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 9.831.5 мянган төгрөгөөр тогтоосон.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 37 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд Засаг даргын нөөц хөрөнгөөс оны тэргүүний шагналд бялуу худалдан авсан, Дархан-Уул аймгийн нутгийн зөвлөлтэй уулзах, Их-Уул сумын ойд оролцох, сумын Засаг дарга АИТХ-д оролцохоор шатахуун зарцуулсан зэрэгтэй холбоотой 1,638.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Баянхайрхан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй байна.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Засаг даргын нөөц сангаас хүүхдийн баярын бэлэг өгсөн болон Санхүү албаны даргад СХС болон ОНХС-ын ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг олгосон 4,634.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж, Гэрэл цахилгаан, түлш халаалт, цалингийн зардлаас хөрөнгө бэлтгэж, хэмнэгдсэн зардлыг зориулалт бус зарцуулсан 7,331.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөгдсөнийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	1	7,331.7	1	7331,7	100%
Зөвлөмж	2	4,634.0	2	4,634.0	100%
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>11,965.7</b>	<b>3</b>	<b>11,965.7</b>	<b>100%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 19,409.5 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа.

Аудитаар нийт 10,014.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 1,638.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 8,376.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, газрын нэгдсэн санд бүртгэлтэй газрыг үнэлж, данс бүртгэлд тусгаагүй зөрчилд зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 10,014.4 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 3,094.3 мянган төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

#### 5.1 Төлбөрийн акт

Дархан-Уул аймгийн нутгийн зөвлөлтэй уулзахад 544.8 мянган төгрөгийн, Их-Уул сумын 100 жилийн ойд оролцоход 87.9 мянган төгрөгийн, сумын Засаг дарга аймгийн ИТХ-д оролцоход 645.4 мянган төгрөгийн шатахуун зарцуулж, Засаг даргын нөөц хөрөнгөөс оны тэргүүний шагналд 360.0 мянган төгрөгөөр бялуу худалдан авч, батлагдсан төсвийг зориулалт бус зарцуулсан, нийт 1,638.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

#### 5.2 Албан шаардлага

Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын аварга малчдын шагналд 3,360.0 мянган төгрөгөөр бэлэг дурсгалын зүйл, аймгийн 100 жилийн ойн арга хэмжээнд оролцоход 3,456.5 мянган төгрөгөөр хоол хүнсний материал худалдаж авч, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот, Зүүн хараа суманд нутгийн золголт хийх, Улиастай сумаас оны тэргүүний шагнал авчрах зэрэгт 1,559.9 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан зөрчилд албан шаардлага өглөө.

#### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Барилга байгууламж, бусад үндсэн хөрөнгө дансанд бүртгэлтэй Хүндэтгэлийн өргөө, "Баян дүнгээ" хадлангийн талбай, спортын талбай, граш, зочид буудал, уурын зуухны барилга, халуун усны барилгын газрыг үнэлж, данс бүртгэлд бүртгээгүй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3 дугаар зүйлийн 3.8-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь газар эзэмших эрх шинээр авах саналаа тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан, холбогдох Газрын алба, сумын газрын даамалд хүсэлт гарган шийдвэрлүүлнэ. Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, толилуулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй барилга байгууламжуудын газрыг үнэлж, данс бүртгэлд бүртгэх;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 10-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлант онд худалдаж авсан үндсэн хөрөнгийг зөв ангилж бүртгээгүй байна.	1	19,000.0			1	19,000.0	1	19,000.0				
Зардлыг зөв ангилж бүртгээгүй байна.	1	409.5			1	409.5	1	409.5				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>19,409.5</b>			<b>2</b>	<b>19,409.5</b>	<b>2</b>	<b>19,409.5</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгуул агад шилжүүлс	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг даргын нөөц хөрөнгөөс оны тэргүүний шагналд бялуу худалдаж авсан.	1	360.0	1	360.0								
Дархан-Уул аймгийн нутгийн зөвлөлтэй уулзах, Их-Уул сумын ойд оролцох, сумын Засаг дарга АИТХ-д оролцох зэрэг албан бус хэрэгцээнд шатахуун зарцуулсан.	1	1,278.1	1	1,278.1								
ЗДНХ-өөс сумын аварга	1	6,816.5			1	6,816.5						

малчдын шагналд аяганы ком, аймгийн 100 жилийн ойн арга хэмжээнд хоол хүнсний материал худалдаж авсан											
УБ, Дархан, Эрдэнэт хот, Зүүн хараа суманд нутгийн золголт хийх, оны тэргүүний шагнал авчрах зэрэг ажилд шатахуун зарцуулсан	1	1,559.8			1	1,559.8					
Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй барилга байгууламжуу дын газрыг үнэлж, бүртгэлд тусгаагүй							1				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>10,014.4</b>	<b>2</b>	<b>1,638.1</b>	<b>2</b>	<b>8,376.3</b>	<b>1</b>				

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Огноо: 2024-02-23

Х.БОЛДБААТАР

Д.БАТ-УНДРАА

**БОЛОВСРУУЛСАН:**

АХЛАХ АУДИТОР

Огноо: 2024-02-23

Ц.ОЮУНСУВД

